



ХЭНТИЙ АЙМАГ  
ТӨРИЙН АЛБАНЫ ЗӨВЛӨЛИЙН САЛБАР ЗӨВЛӨЛИЙН  
ТОГТООЛ

2019 оны 11 сарын 07 өдөр

Дугаар 08

Чингис хот

Нөөцийн сангаас нэр дэвшүүлэх тухай

Төрийн албаны тухай хуулийн 27 дугаар зүйлийн 27.1.3 дахь заалт, Төрийн албаны зөвлөлийн 2019 оны 128 дугаар тогтоолоор баталсан “Төрийн албаны зөвлөлийн салбар зөвлөлийн ажиллах журам”-ын 5.7, 5.8, 2019 оны 17 дугаар тогтоолоор баталсан “Төрийн жинхэнэ албаны нөөц бүрдүүлэх журам”-ын 2.1, 2.1.4-т заасныг тус тус үндэслэн ТОГТООХ нь:

1.Төрийн албаны зөвлөлийн 2018 оны 160 дугаар тогтоолоор “Туслах түшмэлийн ангиллын төрийн жинхэнэ албан тушаалд анх орох иргэний нөөц”-д бүртгэгдсэн иргэдээс өрсөлдсөн албан тушаалдаа хамгийн өндөр оноо авч Дархан сумын Засаг даргын Тамгын газрын Төсөв, төрийн сангийн мэргэжилтний албан тушаалд томилуулахаар нэр дэвшигдэн, ажиллаж байгаад Төрийн албаны тухай хуульд заасны дагуу төрийн жинхэнэ албан тушаалаас түр чөлөөлөгдөж, төрийн жинхэнэ албаны нөөцөд бүртгэлтэй тул Халтарын Өнөрбаярыг Дэлгэрхаан сумын Засаг даргын Тамгын газрын Төсөв, төрийн сангийн мэргэжилтний сул орон тоонд санал болгосугай.

2.Энэхүү тогтоолыг Дэлгэрхаан сумын Засаг даргын Тамгын газрын дарга /З.Ганбаатар/-д хүргүүлэхийг Салбар зөвлөлийн нарийн бичгийн дарга /Ж.Саруултөгс/-д даалгасугай.

ДАРГА



Ж.ГАНБААТАР